



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар A/27

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Оросын 12 айлын гадна 235 м.кв машины зогсоол /Жаргалант сум, Магсаржав баг/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүдэд: Ц.Золбаяр - Ховд Их Сургуулийн багш
Т.Бямбатөмөр - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Б.Балжинням - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн
дарга: Д.Дариймаа - Худалдан авах ажиллагааны албаны
мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Ганзориг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Д.Дариймаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД